

ТАНИЛЦУУЛГА

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
“Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалын
төсөл болосвруулсан тухай танилцуулга*

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын улсын байцаагч нь нийгмийн даатгалын итгэмжит зөвлөх, нийгмийн даатгалын зөвлөх, нийгмийн даатгалын тэргүүлэх гэсэн мэргэшлийн зэрэгтэй байна.”, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/137 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг мөрдөж байна.

Журмын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт “Итгэмжит зөвлөх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 20 хувийн, зөвлөх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 15 хувийн, тэргүүлэх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 10 хувийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр олгоно...” гэж заасан.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Мэргэшлийн зэрэг олгох тухай” А/80 дугаар тушаалаар 133 улсын байцаагч зөвлөх мэргэшлийн зэрэг, 416 улсын байцаагч тэргүүлэх мэргэшлийн зэрэг тус тус авсан байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь улсын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нэмэгдүүлэх судалгаа хийж, ойролцоо чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагын мэргэшлийн зэргийн нэмэгдлийг судлахад 40-48 хувиар тооцон сар бүр олгож байна.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг итгэмжит зөвлөх мэргэшлийн зэрэгтэй улсын байцаагчид 30 хувь, зөвлөх мэргэшлийн зэрэгтэй улсын байцаагчид 25 хувь, тэргүүлэх мэргэшлийн зэрэгтэй улсын байцаагчид 20 хувь болгон өөрчлөх буюу тус тус 10 хувиар нэмэгдүүлэхэд шаардлагатай төсвийг тооцож, Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийг 644.7 сая төгрөг шаардлагатай байгааг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд тусган 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/137 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх зэргийн нэмэгдэл олгох журам”-д заасан “Итгэмжит зөвлөх” мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 30 хувийн, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 25 хувийн, “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 20 хувийн нэмэгдэл

олгох өөрчлөлт оруулахаар “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалын төслийг боловсрууллаа.

Журамд өөрчлөлт орсноор нийгмийн даатгалын салбарын байцаагч, ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллах, бусад ижил төстэй төрийн захиргааны байгууллагын мэргэшсэн ажилтнуудтай ойролцоо түвшинд нэмэгдэл авах, нийгмийн баталгаа сайжрах, өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдэнэ.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ